



What do I need to know if my child is suspended?

Parent/carer information

Миний хүүхдийг сургуулиас түр чөлөөлсөн бол би юу мэдэж байх ёстой вэ?

Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Сургуулиас түр чөлөөлөх арга хэмжээ гэж юу вэ?

Сургуулиас түр чөлөөлөх арга хэмжээ гэдэг нь сургууль тухайн сурагчийг тодорхой хугацаагаар сургууль дээр ирэхгүй байхыг мэдэгдэж байгаа хэрэг юм. Бэлтгэл ангиас 2-р анги хүртэлх сурагчдыг хичээлийн 5 хүртэлх өдрөөр, 3-аас 12-р ангийн сурагчдыг хичээлийн 10 хүртэлх өдрөөр сургуулиас түр чөлөөлөх боломжтой байдаг.

Сурагчийн зохисгүй зан авир хэн нэгнийг хохироосон эсвэл аюул учруулсан тохиолдолд сургуулийн захирал тухайн сурагчийг сургуулиас түр чөлөөлөх магадлалтай.

Сургууль тухайн сурагчийн зохисгүй зан авирт урьд нь өөр бусад арга хэмжээ авч байсан бөгөөд сургуулийн зүгээс сурагчийн зөв зан авирыг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, мөн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах цаг хугацаа хэрэгтэй үед сургуулийн захирал сурагчийг сургуулиас түр чөлөөлөх арга хэмжээ авна. Сургуулийн захирал сургуулиас түр чөлөөлөх шийдвэр гаргахдаа тухайн сурагчийн зан авир, хэрэгцээг харгалзан үзэх ёстой. Хэрэв уг зан авир нь ноцтой эсвэл аюулгүй байдалд нөлөөлөхүйц байвал таны хүүхдийг нэн даруй сургуулиас түр чөлөөлөх боломжтой.

Миний хүүхдийг сургуулиас түр чөлөөлсөний дараа юу болох вэ?

Зохистой бол сургуулийн захирал сурагчийг түр чөлөөлсөн тухай нэн даруй уг сурагчид амаар мэдэгдэх ёстой. Боломжтой бол нэн даруй, үгүй бол 24 цагийн дотор, сургууль сурагчийн эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдэх ёстой. Сургууль танд болон таны хүүхдэд сургуультай уулзаж сургуулиас түр чөлөөлөх арга хэмжээний талаар ярилцах боломжоор хангах ёстой. Мөн сургууль таны хүүхдэд туслах дэмжлэг, стратеги боловсруулах талаар тантай хамтран ажиллах болно.

Сургуулийн захирал уг сурагчийг чөлөөлөх шалтгаан, нөхцөл байдал болон түр чөлөөлсөн хугацааг гаргаж бичсэн мэдэгдлийг өгөх ёстой.

Сургуулиас түр чөлөөлөгдсөн байх хугацаанд таны хүүхэд сургууль дээр ирэх хориотой. Сургуулийн зүгээс таны хүүхдэд сургуулиас түр чөлөөлөгдсөн байх хугацаанд үргэлжлүүлэн суралцахад нь дэмжлэг үзүүлэх ба та болон таны хүүхэдтэй байнга холбоотой байх болно. Чөлөөлөгдсөн байх хугацаанд нь хүүхдийнхээ сайн сайхан байдалд нь дэмжлэг үзүүлэхэд тань туслах мэдээллийг "[Сайн сайхан байдлыг дэмжих зөвлөмжийн хүүдас](#)"-аас авна уу.

Сургуулиас түр чөлөөлөх арга хэмжээг сунгах тухай

Хэрвээ сурагчийг дэмжих төлөвлөгөө боловсруулах цаг хугацаа хангалтгүй эсвэл аюулгүй байдал эрсдэл үүссэн хэвээр байгаа тохиолдолд сургуулийн захирал уг сургуулиас түр чөлөөлөх шийдвэрийг сунгаж болно. Хэрвээ сунгалт батлагдвал сургуулиас түр чөлөөлөх арга хэмжээний хугацаа дуусахаас өмнө эцэг эх, асран хамгаалагчид энэ талаар мэдэгдэх болно.

Сургуулиас түр чөлөөлөх шийдвэрийг би давж заалдаж болох уу?

Болно. Хэрвээ та сургуулийн захирал шударга бус шийдвэр гаргасан, эсвэл холбогдох журам дүрэм зөрчсөн шийдвэр гаргасан хэмээн үзвэл болно. "[Давж заалдах тухай](#)" мэдээлэлтэй танилцана уу.

[Хүүхдээ өмгөөлөх](#) тухай мэдээлэл танд нээлттэй ба мөн [Сургуулийн Хүрээлэлд Баримтлах Дүрэм](#)-д сургуультай хэрхэн холбогдож болох арга замуудын тухай дурдсан байгаа.

Сургуульдаа буцан орохыг төлөвлөх уулзалт гэж юу вэ?

Таны хүүхэд сургуулиас түр чөлөөлөх арга хэмжээ дуусах өдөр эсвэл түүний өмнөх өдөр нь сургуульдаа буцан орох болно. Сургуультай эерэгээр харилцах нь хүүхдийнхээ зан авирыг зохицуулах болон хамтын шийдлийг боловсруулахад маш чухал юм. Таны хүүхэд сургуульдаа буцан орохоос өмнө сургуулиас тантай утсаар холбогдож уулзалт төлөвлөх ба уг уулзалтыг таны хүүхэдтэй ойр ажиллах сургуулийн ажилтантай хийхээр зохион байгуулна.

Уулзалтыг биеэр ирэх, утсаар эсвэл онлайн аар зохион байгуулах боломжтой ба уг уулзалтаар таны хүүхэд сургуульдаа буцан ороход нь туслахад таны хувьд сургуультай хэрхэн хамтран ажиллаж болох тухай ярилцах болно. Та уулзалтанд өөрт [дэмжлэг болох хэн нэгнийг](#) авчрах боломжтой.

Нэмэлт стратеги, дэмжлэг шаардах зохисгүй зан авирын асуудал байгаа тохиолдолд сургуулийн зүгээс эрсдлийг багасгаж, тухайн сурагчид дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулахдаа та болон таны хүүхэдтэй хамтран ажиллах болно. Магадгүй таны хүүхэд өөрөө энэ талаар аль хэдийн төлөвлөсөн байж болох юм. Хэрвээ төлөвлөгөө аль хэдийн бэлэн бол байгаа төлөвлөгөөг таны хүүхдэд тааруулан өөрчилж сургуульдаа буцаж ороход нь дэмжин ажиллах болно. Энэ төлөвлөгөөг та болон таны хүүхдийг дэмжиж ажилладаг сургуулийн бусад ажилтнуудтай хуваалцах болно.

Хэрвээ тухайн зан авир дахин давтагдвал яах вэ?

Хэрвээ зохисгүй зан авир дахин давтагдвал сургуулийн захирал болон сургалтыг дэмжих баг таны хүүхдийн суралцах үйл ажиллагааг дэмжих бусад арга замуудыг тодорхойлох ёстой. Энэ хүрээнд дахин түр чөлөөлөх арга хэмжээ ч орж болзошгүй байдаг. Үүнээс гадна Боловсролын яамны мэргэшсэн ажилтнаас тусалцаа хүсэх хэрэгцээ гарч болно.

Сургуулийн зүгээс надад ямар мэдээллийг өгч чадах вэ?

Юу болсон, яагаад болсон талаар нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг та сургуулиас асууж болно. Сургууль танд өөрийн гаргасан аливаа шийдвэрийн цаад учир шалтгаан, мөн ямар арга хэмжээ авах, танд ямар нэгэн асуудал гарвал яах ёстойг тайлбарлах ёстой байдаг.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.